

Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт эцэг эхчүүдээ

2016-2017 оны шинэ хичээлийн жилд манай аймгийн ерөнхий боловсролын төрийн болон хувийн хэвшлийн сургуульд 19200 гаруй сурагчид, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 7200 гаруй хүүхдүүд сурч хүмүүжихээр сургуульдаа ирж байна.

Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртэй итгэлтэй, шийдвэр гаргах, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёлоо дээдэлдэг иргэн болж төлөвшихөд шааи шаины төр засгийн байгууллага сургууль багш эцэг эх олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа их чухал юм аа.

Манай ард түмний хүмүүн заяаг дээдэлсэн сайхан уламжлалаа өвлөн үр хүүхдүүддээ хөгжин, төлөвших адил тэгш боломж олгохын тулд багш, сургууль, цэцэрлэгийн бие даасан байдал, бүтээлч оролцоо, хамтын ажиллагааны зарчимд суурилан хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих эрх зүйн шинэчлэлийг хийж олон ажлуудын эхлэлийг тавьж байна.

Үүний нэг нь тод жишээ нь бүх шатны боловсрол сургалтын байгууллагад эрүүл аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэх, суралцах амьдрах стандарт шаардлагыг хангасан нийгмийн үйлчилгээг бий болгох асуудал юм. Энэ зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэглэл, ном сурах бичиг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдэд БСШУС-ын сайдын тушаалаар батлагдсан заавал авах 6 төрлийн бараа бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчдээс нэг дороос хямд төсөр үнээр авах боломжийг эцэг эхчүүдэд бүрдүүлсэн “Хичээлийн шинэ жил 2016” үзэсгэлэн худалдааны нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

Бидний хүүхдүүд мэдлэг, боловсролтой төдийгүй эрүүл чийрэг эерэг зан суртахуунтай, хүмүүжил төлөвшилтөй, амьдрах ухаантай, эх оронч үндэсний бахархалтай иргэд болох ёстой. Хүүхэд бүр эрүүл саруул байж эрдэм мэдлэгтэй иргэн болоход сургууль багш эцэг эхчүүд та бүхний хамтын ажиллагаа түүнийг дэмжсэн орон нутгийн төр захиргааны оновчтой бодлого шийдвэр нэн чухал байна. Бид хамтдаа үүнийг шийдвэрлэж чадна.

Хичээлийн шинэ жил эхлэх бүрт манай хотын хүүхэд бүр авьяас билгээ нээн хөгжүүлж, ертөнцийн түмэн гайхамшигийг мэдэрч, ухаан бодол, уран сэтгэмжээ уралдуулах гэж сургууль, цэцэрлэгээ яаран зорьдог байгаасай,

гэж та бид туйлын ихээр хүсч байна. Хүүхдүүдээ аз жаргалтай хотын мэдлэг боловсролтой иргэн болгохын төлөө хамтдаа ажиллацгаая. Өнөөдрийн өргөтсөн үзэсгэлэн худалдаат үйл ажиллагаа нээснийг мэдэгдье.